# “ХААН СОЁМБО АУДИТ- ХХК

# САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2025/105/НА-СТА-ТШЗ**


Аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мөнх-Оргил

Утас: 99039344 Цахим хаяг: munkhorgill@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа

Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитор: Л.Оюунчимэг

Утас: 99142061

Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com


Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/247
танай ______ -ны № ______ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААННУУР СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Т.ЦЭНДМАА ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 15,105.5 мянган төгрөгөөр, Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 17,378.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 6,897.6 мянган төгрөгийн 5 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчилтэй холбоотой 5 зөвлөмжийг хүргүүллээ.

### Бусад асуудлын хэсэг

Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал нь 2024 онд аймгийн Боловсролын газрын даргатай гэрээ байгуулан ажиллаж, хэрэгжилтийг 73.4 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн гэж үнэлсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Ц-нуур

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **205,463,263.75** | **282,777,114.39** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 108,870,677.10 | 162,654,063.28 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 108,870,677.10 | 162,654,063.28 |
| **3121** | **Төгрөг** | 108,870,677.10 | 162,654,063.28 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 108,870,677.10 | 162,654,063.28 |
| **33** | **АВЛАГА** | 1,208,088.86 | 8,646,058.32 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,208,088.86 | 8,646,058.32 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 00.00 | 986,700.00 |
| 33100 | Урьдчилж гарсан зардал | 00.00 | 986,700.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 95,384,497.79 | 110,490,292.79 |
| **351** | **Түүхий эд материал** | 413,000.00 | 1,032,000.00 |
| 35130 | Эм боох материал | 413,000.00 | 1,032,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 94,971,497.79 | 109,458,292.29 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 421,500.00 | 5,375,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 50,525,733.43 | 58,302,033.43 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 8,472,375.00 | 18,072,490.00 |
| 35460 | Хүнсний материал | 12,547,590.00 | 4,704,170.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 23,004,299.36 | 23,004,299.36 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **328,612,524.03** | **316,095,906.19** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 328,612,524.03 | 316,095,906.19 |
| **392** | **Биет хөрөнгө** | 301,649,414.19 | 287,851,416.43 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 315,239,904.31 | 315,239,904.31 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -76,649,923.77 | -90,387,931.05 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 69,294,274.00 | 86,672,619.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -33,000,527.08 | -45,888,515.28 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 38,126,984.63 | 38,126,984.63 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -15,141,496.82 | -18,921,844.18 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,400,000.00 | 2,400,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,600,000.08 | -2,400,000.00 |
| 39217 | Ном | 3,010,199.00 | 3,010,199.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **26,963,109.84** | **28,244,489.76** |
| 39301 | Програм хангамж | 1,024,350.00 | 2,524,350.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -437,240.16 | -655,860.24 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 26,376,000.00 | 26,376,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **534,075,787.78** | **598,873,020.58** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **129,492.00** | **4,689,279.19** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 129,492.00 | 4,689,279.19 |
| **413** | **Өглөг** | 129,492.00 | 4,689,279.19 |
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 129,492.00 | 1,134,984.99 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | 3,227,640.00 |
| **4136** | **Бусад өглөг** | | 326,654.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 144,200.00 |
| | Хувь хүмүүст төлөх өглөг | | 182,454.20 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **533,946,295.78** | **594,183,741.39** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 533,946,295.78 | 594,183,741.39 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 41,903,171.00 | 41,903,171.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 41,903,171.00 | 41,903,171.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 196,801,971.13 | 257,039,416.74 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 196,801,971.13 | 196,801,971.13 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 60,237,445.61 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 295,241,153.65 | 295,241,153.65 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **534,075,787.78** | **598,873,020.58** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **503,546,100.00** | **731,758,345.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,343,000.00** | **24,605,245.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 10,343,000.00 | 24,605,245.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 35,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - ҮХ | 10,343,000.00 | 24,570,245.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – БМ | | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **493,203,100.00** | **707,153,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 462,203,100.00 | 668,153,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 462,203,100.00 | 668,153,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 31,000,000.00 | 39,000,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 31,000,000.00 | 39,000,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **486,939,484.17** | **671,520,899.39** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **486,939,484.17** | **671,520,899.39** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 486,939,577.07 | 671,514,816.24 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **307,856,258.40** | **475,601,236.68** |
| 210101 | Үндсэн цалин | 200,196,062.40 | 327,267,128.82 |
| 210102 | Нэмэгдэл | 97,188,744.00 | 135,562,287.86 |
| 210104 | Урамшуулал | 10,471,452.00 | 12,771,820.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **39,171,148.00** | **59,168,754.87** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,185,426.00 | 37,926,354.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,078,562.00 | 4,911,007.90 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,354,761.00 | 2,385,514.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 665,495.00 | 2,186,518.55 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,886,904.00 | 8,932,593.46 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **15,359,355.75** | **18,193,801.85** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,030,252.75 | 6,621,856.85 |
| 210302 | Түлш, халаалт | 9,771,625.00 | 11,472,445.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,557,478.00 | 99,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 51,694,370.00 | 56,119,060.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 167,900.00 | 57,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 51,526,470.00 | 56,061,560.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **13,538,250.00** | **11,200,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 13,538,250.00 | 11,200,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **852,900.00** | **53,200.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 852,900.00 | 53,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 58,482,294.92 | 51,178,792.84 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,784,217.00 | 14,325,800.00 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 8,880,200.00 | 5,458,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 32,797,877.92 | 31,394,962.84 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,907.10** | **6,083.15** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,907.10 | 6,083.15 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,907.10 | 6,083.15 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **16,606,615.83** | **60,237,445.61** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 00.00 | 00.00 |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 00.00 | 00.00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **16,606,615.83** | **60,237,445.61** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 41,903,171.00 | 295,241,153.65 | 180,195,355.30 | 517,339,679.95 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 41,903,171.00 | 295,241,153.65 | 180,195,355.30 | 517,339,679.95 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 16,606,615.83 | 16,606,615.83 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **41,903,171.00** | **295,241,153.65** | **196,801,971.13** | **533,946,295.78** |
| D01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **41,903,171.00** | **295,241,153.65** | **196,801,971.13** | **533,946,295.78** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **41,903,171.00** | **295,241,153.65** | **196,801,971.13** | **533,946,295.78** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 60,237,445.61 | 60,237,445.61 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **41,903,171.00** | **295,241,153.65** | **257,039,416.74** | **594,183,741.39** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **493,203,100.00** | **707,188,100.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 35,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **493,2030,100.00** | **707,153,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 462,203,100.00 | 668,153,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 462,203,100.00 | 668,153,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 31,000,000.00 | 39,000,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 31,000,000.00 | 39,000,000.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **449,042,041.10** | **650,181,913.82** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **449,042,041.10** | **650,181,913.82** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **449,042,041.10** | **650,181,913.82** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 304,588,715.94 | 483,654,576.57 |
| 210101 | Үндсэн цалин | 200,196,060.41 | 316,725,150.03 |
| 210102 | Нэмэгдэл | 93,921,204.19 | 154,323,946.14 |
| 210104 | Урамшуулал | 10,471,451.34 | 12,605,480.40 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **38,482,035.16** | **57,365,437.25** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,636,728.74 | 40,777,737.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,895,485.15 | 4,147,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,536,879.89 | 3,584,976.79 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 569,474.73 | 2,604,934.27 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,843,466.65 | 8,293,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **15,995,092.90** | **27,793,916.85** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6237602.90 | 6,412,769.23 |
| 210302 | Түлш, халаалт | 8,200,000.00 | 21,281,647.62 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,557,490.00 | 99,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **54,990,790.00** | **44,990,500.00** |
| 210502 | Хоол, хүнс | 54,990,790.00 | 44,990,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,000,000.00 | 11,200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,000,000.00 | 11,200,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 852,900.00 | 1,039,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 852,900.00 | 1,039,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,127,600.00 | 24,131,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,569,000.00 | 18,641,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,558,600.00 | 5,669,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,907.10** | **6,083.15** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,907.10 | 6,083.15 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,907.10 | 6,083.15 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **44,161,058.90** | **57,006,186.18** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **3,222,800.00** |
| **5** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **3,222,800.00** |
| **6** | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 3,222,800.00 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 44,161,058.90 | 53,783,386.18 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 64,709,618.20 | 108,870,677.10 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 108,870,677.10 | 162,654,063.28 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (улсын төсөв)

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | **108,870,677.10** | **(108,870,677.10)** | - |
| **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **720,333,300.00** | **614,404,713.82** | **105,928,586.18** | **85,3%** |
| **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **720,333,300.00** | **614,404,713.82** | **105,928,586.18** | **85,3%** |
| **Бараа, үйлчилгээний зардал** | **720,333,300.00** | **614,404,713.82** | **105,928,586.18** | **85,3%** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **596,001,700.00** | **483,654,576.57** | **92,347,123.43** | **84.0%** |
| Үндсэн цалин | 395,682,300.00 | 316,725,150.03 | 78,957,149.97 | 80.0% |
| Нэмэгдэл | 173,803,400.00 | 154,323,946.14 | 19,479,453.86 | 88.8% |
| Урамшуулал | 6,516,000.00 | 12,605,480.40 | (6,089,480.40) | 193.5% |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **67,034,600.00** | **57,365,437.25** | **9,669,162.75** | **85.6%** |
| Тэтгэврийн даатгал | 45,584,900.00 | 40,777,737.25 | 4,807,162.75 | 89.5% |
| Тэтгэмжийн даатгал | 5,361,400.00 | 4,147,100.00 | 1,214,300.00 | 77.4% |
| ҮОМШӨ ний даатгал | 2,681,300.00 | 2,073,400.00 | 607,900.00 | 77.3% |
| Ажилгүйдлийн даатгал | 2,681,300.00 | 2,073,400.00 | 607,900.00 | 77.3% |
| Эрүүл мэндийн даатгал | 10,725,700.00 | 8,293,800.00 | 2,431,900.00 | 77.3% |
| **Нормативт зардал** | **46,940,500.00** | **44,990,500.00** | **1,950,000.00** | **95.8%** |
| Хоол, хүнс | 46,940,500.00 | 44,990,500.00 | 1,950,000.00 | 95.8% |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **1,906,900.00** | **1,906,900.00** | **00.00** | **100%** |
| Мэдээллийн технологийн зардал | 1,906,900.00 | 1,906,900.00 | 00.00 | 100% |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **28,449,600.00** | **26,487,300.00** | **1,962,300.00** | **93.1%** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 22,779,800.00 | 20,817,500.00 | 1,962,300.00 | 91.4% |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,669,800.00 | 5,669,800.00 | 00.00 | 100% |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **720,333,300.00** | **668,188,100.00** | **52,145,200.00** | **92.8%** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **668,257,800.00** | **668,153,100.00** | **104,700.00** | **100%** |
| Улсын төсвөөс санхүүжих | 668,257,800.00 | 668,153,100.00 | 104,700.00 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 52,075,500.00 | 35,000.00 | 52,040,500.00 | 0.1% |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 35,000.00 | (35000) | - |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 52,075,500.00 | - | 52,075,500.00 | - |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **108,870,677.10** | | - |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **162,654,063.28** | | - |

### Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (орон нутгийн төсөв)

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | **0.00** | **(0.00)** | - |
| **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **39,000,000.00** | **38,987,833.70** | **12,166.30** | **99.96** |
| **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **39,000,000.00** | **38,987,833.70** | **12,166.30** | **99.96** |
| **Бараа, үйлчилгээний зардал** | **39,000,000.00** | **38,987,833.70** | **12,166.30** | **99.96** |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **27,800,000.00** | **27,787,833.70** | **12,166.30** | **99.96** |
| Гэрэл цахилгаан | 6,300,000.0 | 6,412,769.23 | (112,769.23) | **101.8** |
| Түлш, халаалт | 20,000,000.00 | 21,275,564.47 | (1,275,564.47) | **106.4** |
| Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 99,500.00 | 1,400,500.00 | **6.6** |
| **Эд хогшил худалдан авах** | **11,200,000.00** | **11,200,000.00** | **00.00** | **100.0** |
| Урсгал засвар | 11,200,000.00 | 11,200,000.00 | 00.00 | **100.0** |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **39,000,000.00** | **38,987,833.70** | **12,166.30** | **99.96** |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **39,000,000.00** | **38,987,833.70** | **12,166.30** | **99.96** |
| Орон нутгийн төсвөөс | 39,000,000.00 | **38,987,833.70** | **12,166.30** | **99.96** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | **0.00** | **(0.00)** | - |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | **0.00** | **(0.00)** | - |

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар төсвийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 6,897.6 мянган төгрөгийн 4 зөрчил илэрсэн зөрчлийг арилгах 4 зөвлөмж хүргүүлсэн.

### 5.1 Аудитын залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой дараах залруулга хийгээгүй.

### 5.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 5.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй.

### 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Зардлын данстай холбоотой**

*Илрүүлэлт 1*:

Төсөв захирагчийн шийдвэрээр ажлын хэсэг байгуулаагүй, дүгнэлт гаргаагүй, ур чадварыг хагас жил тутам үнэлээгүй, төсөв захирагчийн 5 удаагийн тушаалаар 25 багш, ажилтны ур чадварын нэмэгдэлд нийт 16,359.8 мянган төгрөгийг олгосон. Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгэм хамгааллын сайд, Сангийн сайдын “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/85, А/10/9 дүгээр хамтарсан

тушаалтай нийцээгүй ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Ур чадварын нэмэгдлийг олгохдоо ажлын хэсэг байгуулж, үнэлэх.

*Илрүүлэлт 2*:

Илүү цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж, баталгаажуулаагүй, төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас хөтлөхгүйгээр нийт 13 багш, ажилтанд 17,810.0 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгосон байна. Энэ нь Засгийн газрын “Журам батлах тухай” 382 нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт хүснэгтийн агуулга хэсэгт нэмэгдэл хөлс тооцох цагт гүйцэтгэсэн ажлын товч агуулгыг үндэслэл тус бүрээр бичнэ заалттай нийцэхгүй ба нийцсэнэ бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Илүү цагийг олгохдоо Засгийн газрын “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 4-д “Төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт хүснэгт хөтлөх”

**Зардлын данстай холбоотой**

*Илрүүлэлт 3*:

Тус цэцэрлэг нь тайлант онд “Овоо нам” ХХК, “Сүлд бумбат” ХХК-тай тус тус хүнсний бараа бүтээгдэхүүн худалдан авах тухай гэрээнд хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээнээс илүү гэрээнд заасан 13 нэр төрлийн бүтээгдэхүүнийг огт нийлүүлээгүй зэрэг нийт 6,897.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.11-д “гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх”-т заасныг зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Худалдан авах ажиллагааны журам баримталж ажиллах зөвлөмж өглөө.

2. *Ахмадын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой*

*Илрүүлэлт 4*:

Тус байгууллага нь Ахмадын тухай хуулийн холбогдох заалтын дагуу ахмадын сан байгуулж, жилийн төсөвтөө төлөвлөж батлуулаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална”, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-тай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*Ахмадын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хууль журмын дагуу байгууллагын төсвийн төсөлдөө ахмадын санг төлөвлөн батлуулж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, fas.audit.mn системд оруулж, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/Мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Худалдан авах гэрээнд заасан нэр төрөл, тоо хэмжээ, үнийн дүнг баримтлаагүй 6,897.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. | 1 | 6,897.6 | | | | | 1 | 6,897.6 |
| Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас хөтлөхгүйгээр нийт 13 багш, ажилтанд 17,810.0 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгосон байна. | 1 | | | | | | | |
| Үнэлгээний баг томилохгүйгээр төсөв захирагчийн 5 удаагийн тушаалаар 25 багш, ажилтны ур чадварын нэмэгдэлд нийт 16,359.8 мянган төгрөгийг олгосон. | 1 | | | | | | | |
| **Дүн** | 3 | 6,897.6 | | | | | **1** | 6,897.6 |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Ахмадын тухай хуулийн дагуу ахмадын сан байгуулж ажиллаагүй. | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Дүн | 1 | 0 | | | | | 1 | 0 |